



ПРЕМИУМ НЭКСУС ХК

2025 ОНЫ 3-Р УЛИРЛЫН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Холбоо барих:
И-мэйл: investor@cumongol.mn

Премиум Нэксус ХК

■ ИРЭЭДҮЙГ ЧИГЛЭСЭН МЭДЭГДЛИЙН ТАЛААРХ АНХААРУУЛГА

Премиум Нэксус ХК нь энэхүү тайланд “ирээдүйг чиглэсэн” зарим мэдэгдэл агуулагдсан болно. Тухайлбал, тус тайланд “бид таамаглаж байна, бид тооцоолж байна, бид зорьж байна, бид төлөвлөж байна” гэх мэт үгстэй ойролцоо үг,мөн ирээдүй цагийг илэрхийлэх үгс ашиглагдсан болно.Ирээдүйг чиглэсэн мэдэгдэл нь ирээдүйд болох үйл явдал,нөхцөл байдлын баталгаа биш бөгөөд бидний таамагласан нөхцөл байдал биелэхгүй байх магадлалтай ба тэдгээр таамаглалуудад хэт найдах нь учир дутагдалтайг анхаарна уу.

Компанийн бизнесийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлага нь эрсдэл, тодорхойгүй байдал гэх мэт хүчин зүйлс, мөн үүгээр хязгаарлагдахгүй зүйлсээс хамаарч материаллаг зөрүүтэй байж болно. Тиймээс, эдгээр эрсдэл болон тодорхойгүй байдлыг харгалзан үзэж ирээдүйг чиглэсэн мэдэгдэл, төсөөллийг шууд утгаар нь бодитоор биелнэ хэмээн авч үзэх нь өрөөсгөл юм. Мөн, компанийн зүгээс шинэ мэдээ мэдээлэл болон ирээдүйд гарах ялгаатай үр дүн эсвэл аливаа бусад шаардлагын улмаас энэхүү тайланд тусгагдсан ирээдүйд чиглэсэн таамаглалуудыг шинэчлэх эсвэл засварлах аливаа үүрэггүй болохыг мэдэгдэж байна.

Агуулга

Компанийн тухай	03
Хувьцааны мэдээлэл	08
CU Конвиниенс дэлгүүрийн бизнес	10
2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд	16
Нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтүүдийн товч танилцуулга	34

КОМПАНИЙН ТУХАЙ


Компанийн тухай

■ ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН УДИРДЛАГА



Компанийн тухай

■ ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН БИЗНЕСИЙН БҮТЭЦ



Компанийн тухай

■ ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ БОЛОН ПРЕМИУМ НЭКСУС

Премиум Корпорэйшн 2015 онд өөрийн 100%-ийн хөрөнгө оруулалтаар Сэнтрал Экспресс нэршлээр Монголын анхны конвиненс дэлгүүрийг нээж байв. 2017 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг байгуулж, 2018 оны 8-р сард дэлхийн конвиненс дэлгүүрийн жишиг стандартын төлөөлөл болох БНСУ-д 18,500 гаруй дэлгүүрээр зах зээлийг манлайлагч CU брэндийн үүсгэн байгуулагч БНСУ-ын жижиглэн худалдааны тэргүүлэгч Би Жи Эф Ритэйл ХК-иас Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 10%-ийг эзэмших стратегийн хөрөнгө оруулалт татаж, хамтдаа CU брэндийг Монголд нэвтрүүлсэн.

2021 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO амжилттай хийж хувьцаат компани болсон ба улмаар 2023 оны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлаар хөгжлийн дараагийн шатандаа гарах шийдвэрийг баталж нэрээ Премиум Нэксус ХК болгон өөрчилжээ. Уг өөрчлөлтийн эхлэл нь шинээр хувьцаа гаргах замаар босоо интеграцийн хөрөнгө оруулалт болох Чингис Шар Айраг ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК болон Стора Централ ХХК нарыг нэгтгэсэн явдал юм.



Компанийн тухай

■ Премиум Нэксус ЭКОСИСТЕМ ба түүний давуу талууд

Борлуулалт болон ашигт ажиллагааны өсөлт:

Ханган нийлүүлэгчдийн хувьд СУ сүлжээ дэлгүүртэй хамтран борлуулалтын прогнозоо улам оновчлох, эрэлтээ зөв таамаглах, үргүй зардлаа бууруулах боломжтой болсноор хамтын ашигт ажиллагаа нэмэгдэх болно.

Логистик болон нэгдсэн түгээлтийн үр ашиг:

Монголын дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд бүтээгдэхүүний нийт өртгийн 30 орчим хувийг логистикийн зардал эзэлж байгаа нь дэлхийн дунджаас 2-3 дахин өндөр үзүүлэлт юм. Премиум Нэксус нь логистикийн дэд бүтцийн сайжруулалт хийснээр дээрх үр ашиггүй байдлыг арилгах болно.

Хөрөнгө оруулагчдын нэгдмэл ашиг сонирхол:

СУ сүлжээ дэлгүүрийг түшсэн, түүнтэй хамаарал бүхий бизнесүүдийг нэг дор нэгтгэснээр тэдгээр бизнесүүд хамтын хүчээр үлэмж үнэ цэнийг бий болгох боломжтой. Ингэснээр хөрөнгө оруулагчид энэхүү синергээс бий болох бүх боломжийг хүртэх нөхцөл бүрдэнэ.

Байгал орчин, Нийгэм, Засаглалын өндөр стандарт өргөн цар хүрээ:

СУ сүлжээдэлгүүрийнханганнийлүүлэгчид,ялангуяажижигдундүйлд вэрлэгчид энэхүүэко-системд нэгдсэнээр, Премиум Нэксусийнолон улсынжишигтнийцсэн БОНЗ-ийн практикийг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

Үйлчлүүлэгчидийн сэтгэл ханамж:

СУ сүлжээ дэлгүүр үйлдвэрлэгчидтэйгээ хамтран бүтээгдэхүүн хөгжүүлснээр хэрэглэгчдийн хэрэгцээнд бүрэн нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж бүрдэнэ. Ингэснээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийг өндөр түвшинд хүргэх, үнэнч хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

Ажилтнуудын өсөж дэвших боломж, сэтгэл ханамж:

Монголын томоохон хөрөнгө оруулалтын компанийн нэг хэсэг болж ажиллах, групп компани дотроо өсөж хөгжих, Премиум туршлагаас суралцах зэрэг боломжууд ажилтнуудад нээлттэй болно.

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Хувьцааны мэдээлэл


■ ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Премиум Нэксус ХК (CUMN):

Хаалтын ханш: ₮186

Зах зээлийн үнэлгээ: 207,250,878,324





CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮРИЙН БИЗНЕС

CU Конвиниенс дэлгүүрийн бизнес

■ CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮРИЙН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО



Эрхэм зорилго

Дэлхийн стандартын
үйлчилгээгээр
хүмүүсийн өдөр
тутмын амьдралыг
хялбаршуулна



Алсын хараа


Үйлчилгээгээрээ
дэлхийд танигдана



Үнэт зүйл, бизнесийн үзэл баримтлал

- Амжилт гаргагч
- Өсөх
сэтгэлгээтэй
- Үйлчлүүлэгч
төвтэй Шилдэг
хамтрагч

■ **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ**



Конвиниенс дэлгүүрүүд нь үйлчлүүлэгчдэд хамгийн ойр, үргэлж нээлттэй байж хэрэглэгчдийн хэрэгцээт бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол нийлүүлдгээрээ онцлогтой. Премиум Нэксус ХК нь CU брэндийн конвиниенс дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд хэрэгцээт бүтээгдэхүүн үйлчилгээг 24 цагийн турш хамгийн тав тухтай, хүртээмжтэй хүргэхээр зорин ажиллаж байна. Бид бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд тасалдалгүй тогтмол хүргэж, тэдний сэтгэл ханамжийг хамгийн өндөр түвшинд байлгахын тулд бүтээгдэхүүн үйлчилгээний ялгарал, логистик, технологийн цогц шийдлийг бий болгон ажиллаж байна.

■ ПРЕМИУМ НЭКСУС ХК ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Хамгийн их сүлжээ дэлгүүртэй

2024 оны Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгж #7

Тэргүүлэгч жижиглэн худалдааны компани

Зах зээлийн үнэлгээ : 207 тэрбум төг



Нэгтгэсэн борлуулалт:
587+ тэрбум төг



Дэлгүүрийн тоо:
515



Ажиллагсдын тоо:
5,000+



Өдрийн хэрэглэгчдийн тоо:
220,000+



Хамтран
ажиллагчид:
500+



Хувьцаа эзэмшигчид:
10,340+



+515 Дэлгүүрүүд
4,200+ Дэлгүүрийн ажилтнууд




Логистикийн бааз
120+ Логистикийн ажилтнууд



2 Түгээлтийн төв
240+ Агуулахын ажилтнууд




Хоолны үйлдвэр
220+ Үйлдвэрийн ажилтнууд




Төв оффис
240+ Оффисын ажилтнууд

■ CU КОНВЕНИЕНС ДЭЛГҮҮРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Үйлчлүүлэгчдийн тоо (сая)



Ажилласан хүний тоо*




*Ажилласан хүний тоо буюу тухайн тайлант хугацаанд төлсөн нийгмийн даатгал төлөгчдийн тоо давхардаагүй дүнгээр.

Дэлгүүрийн тоо

	3-р улиралд нээсэн дэлгүүр	2025Q3
УБ	+16	425
Орон нутаг	+11	90
Нийт	+27	515

Дэлгүүрийн тоо



■ CU ХАРЬЦУУЛСАН БОЛОН НИЙТ ДЭЛГҮҮРИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл


	2025 оны 3-р улирал
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	9.6%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	7.5%
Сагсны үнийн өсөлт	1.9%

Харьцуулсан дэлгүүрийн тоо: 395

Нийт дэлгүүрийн гүйцэтгэл

	2025 оны 3-р улирал
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	2.9%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	-1.0%
Сагсны үнийн өсөлт	4.0%

Нийт дэлгүүрийн тоо: 417 → 515



2025 ОНЫ ОНЫ 3-Р УЛИРЛЫН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд


■ **SU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР**

Гол онцлох үйл явдлууд

- 3-р улиралд 27 шинэ дэлгүүр нээж, 7 дэлгүүр хааснаар нийт 515 дэлгүүртэй болсон.
- Улаанбаатар хотод 425, орон нутагт 90 дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.

Нийт 16 аймагт хүрээгээ тэлсэн.

Дэлгүүрийн тоо	2024	2025Q3
SU	445	515



SU Конвиниенс дэлгүүр нь Монгол орныг ирэх жуулчид болон нутгийн иргэдэд олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ хүргэхээр Улаанбаатараас алслагдмал аймгууд болох Хөвсгөл, Баянхонгор, Дорнод, Сүхбаатар аймгуудад шинээр салбар дэлгүүрээ нээн Монгол орны 16 аймагт хөл тавилаа. SU конвиниенс дэлгүүр нь Монгол орон даяар амжилттай өргөжин тэлснээр бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, шинээр ажлын байрууд бий болгохын зэрэгцээ орон нутгийн иргэд, байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлж, хөгжил дэвшлийг хамтдаа бүтээх боломж бүрдэж байгаа юм.

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР



Budget-Friendly meal boxes

Дунджаас хямд үнэ бүхий олон төрлийн шөл, савтай хоолыг зах зээлд танилцуулж, борлуулж эхэллээ. Байнгын шинэчлэлт, хөгжүүлэлт хийж шинэ төрлийн амтыг турших боломжийг хэрэглэгчиддээ нээж байна.



Japanese Sando

Япон хэв маягийн шинэ бүтээгдэхүүн – зөөлөн, захгүй талхтай сэндвич нэвтрүүлээ. Захгүй зөөлөн талх нь шанзны амтыг улам тодруулж буй бөгөөд өдрийн аль ч цагт тохиромжтой бүтээгдэхүүн юм.



Уламжлалт цагаан идээ

Монголын уламжлалт цагаан идээнээс бүрдсэн багцыг орчин үеийн хэрэглээнд нийцүүлэн хэрэглэгчдэд санал болгож эхэллээ.



Үхрийн дайвар мах болон бусад олон улсад алдартай нэр төрөл бүхий махан зуушыг зах зээлд нэвтрүүлээ.

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ 500 ДАХ САЛБАРАА АМЖИЛТТАЙ НЭЭЛЭЭ

Монгол Улсын жижиглэнгийн худалдааны салбарт тэргүүлэгч Премиум Нэксус ХК нь “CU” брэндийг Монголд нэвтрүүлсний 7 жилийн ойдоо тохиолдуулан 500 дахь салбараа Төв аймгийн Цонжинболдогт нээлээ.

Энэхүү газар нь домогт өгүүлэгддэгээр 1177 онд Эзэн Чингис хаан дүү нарын хамт Хэрэйдийн Ван Тоорилд бараалхаад буцах замдаа ташуур олсон хэмээн бэлгэдэлтэй түүхтэй газар юм. Монгол ёсонд эр хүн ташуур олох нь сайн ерөөл, ирээдүйн их үйлийн бэлгэдэл хэмээн үздэг билээ.

Ийнхүү ивээлтэй, түүхэн дурсгалт газарт 500 дахь салбараа нээсэн нь CU брэндийн тасралтгүй хөгжил, хамт олны тууштай хөдөлмөрийн бэлгэ тэмдэг төдийгүй үндэсний жижиглэнгийн салбарын шинэ шатны хөгжилд хүрсэн чухал үйл явдал боллоо.



2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ СҮХБААТАР АЙМАГТ САЛБАРАА НЭЭЛЭЭ

Монгол Улсын жижиглэнгийн худалдааны салбарт тэргүүлэгч **Премиум Нэксус ХК** нь “**CU**” брэндийг Монголд нэвтрүүлсний 7 жилийн ойгоо тохиолдуулан 500 дахь салбараа Төв аймгийн Цонжинболдогт нээлээ.

Энэхүү газар нь домогт өгүүлэгддэгээр 1177 онд Эзэн Чингис хаан дүү нарын хамт Хэрэйдийн Ван Тоорилд бараалхаад буцах замдаа ташуур олсон хэмээн бэлгэдэлтэй түүхтэй газар юм. Монгол ёсонд эр хүн ташуур олох нь сайн ерөөл, ирээдүйн их үйлийн бэлгэдэл хэмээн үздэг билээ.

Ийнхүү ивээлтэй, түүхэн дурсгалт газарт 500 дахь салбараа нээсэн нь CU брэндийн тасралтгүй хөгжил, хамт олны тууштай хөдөлмөрийн бэлгэ тэмдэг төдийгүй үндэсний жижиглэнгийн салбарын шинэ шатны хөгжилд хүрсэн чухал үйл явдал боллоо.



2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ “ПРЕМИУМ НЭКСУС” ХК-ИЙН БҮРТГЭЛ II АНГИЛЛААС I АНГИЛАЛ РУУ ШИЛЖЛЭЭ




2025 оны 9-р сарын 05-ны өдөр Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн Гүйцэтгэх захирлын А/358 тоот тушаалаар Премиум Нэксус ХК-ийн бүртгэл II ангиллаас I ангилалд албан ёсоор шилжсэн.

Энэхүү шилжилт нь компанийн сайжирсан санхүүгийн үзүүлэлт, ил тод байдал, хамгийн өндөр түвшний засаглалын стандартын дагуу үйл ажиллагаа явуулж буй байдлыг тусгасан үр дүн юм.

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ "СОЁЛТОЙ АЯЛЪЯ" АЯНЫГ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ



SU брэнд, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо болон Аялал жуулчлалын технологийн төв хамтран Монгол орноороо "СОЁЛТОЙ АЯЛЪЯ" аяныг хамтран хэрэгжүүлсэн. Дотоодын болон гадны жуулчлал эрс нэмэгддэг цаг үеийг тохиолдуулсан хэрэгжүүлсэн энэхүү аяны зорилго нь аялагчдын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эх дэлхийгээ хайрлан хариуцлагатай аялахыг уриалах, аяллын боловсрол олгоход чиглэсэн юм.

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ DELIVERY ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЛЭЭ


Орчин үед хүргэлтийн үйлчилгээ хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болж байна. Энэ чиг хандлагад нийцүүлэн **CU** конвениенс дэлгүүр 2025 оны 9-р сараас эхлэн хүргэлтийн үйлчилгээгээ дахин сэргээн нэвтрүүллээ.

Тус үйлчилгээ нь анх COVID-19 цар тахлын үеэр хэрэгжиж байсан бөгөөд тодорхой хугацаанд завсарласны дараа одоо сонгогдсон бүсүүдийг хамруулан дахин үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Хэрэглэгчид CU APP-аар дамжуулан бүтээгдэхүүнээ хүргэлтээр захиалах, хүргэлтийн явцыг реал тайм статусаар хянах боломжтой болсон нь хэрэглээний тав тухыг улам нэмэгдүүлж байна.

Мөн цаашид хүргэлтийн хамрах хүрээг шат дараатайгаар өргөжүүлэх, системтэй цэгүүдийг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа нь компанийн дижитал үйлчилгээний хөгжлийн стратегийн чухал алхам юм.

Хүйтний улирал эхэлж буй энэ үед гэртээ байгаа ээжүүд болон завгүй хэрэглэгчдэд зориулсан энэхүү шийдэл нь хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн, нүдээ олсон үйлчилгээ болж байна.



2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ БОЛОН ПРЕМИУМ НЭКСУС ХК ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



Санамж бичигт ЭМЯ-ыг төлөөлөн Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Премиум Нэксус ХК-ийг төлөөлөн Борлуулалт, үйлчилгээний газрын захирал Ц.Номинзол нар гарын үсэг зурж, баталгаажуулав.

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын дотоод орчин болон ариун цэврийн өрөө байгууламжийг засварлаж, иргэдэд хүртээмжтэй, эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдэд тав тухтай, шаардлага хангасан орчин бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яам болон Премиум Нэксус ХК хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагаа боллоо.



Санамж бичгийн хүрээнд Премиум Нэксус ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд:

- Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын ариун цэврийн өрөө болон холбогдох нөхцөлийг сайжруулахад хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын хэлбэрээр хамтран ажиллах;
- Байгууллагын тулгамдсан ариун цэврийн өрөө болон дэд бүтцийн асуудлыг судалж, хэрэгцээ шаардлагад үндэслэн үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Ажлын зураг төсөл, гүйцэтгэл, хүлээлгэн өгөх ажиллагааг холбогдох хууль, журам, эрүүл ахуйн болон барилгын норм, стандартад нийцүүлэн зохион байгуулахаар тохиролцлоо.

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд




■ УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ ДЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн албан хаагчид болон үйлчлүүлэгчдийн тав тухтай байдлыг хангах үүднээс эмнэлгийн яаралтай тусламжийн 2-р давхрын дотрын тасгийн ажилчдын 350 мкв оффис, ариун цэврийн өрөө, шүршүүрийн өрөө, өвчтөний ар гэртэй уулзах уулзалтын өрөө, хувцас солих өрөө, ажилчдын амрах өрөөний бүтэн дотор засварыг хийн нийт 172 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, эмч ажилчдын цэвэр цэмцгэр тав тухтай ажиллах орчныг бүрдүүлэн хүлээлгэн өглөө.



2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ ДЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ



Цэргийн төв эмнэлгийн амбулаторийн барилгын 1, 2, 3 давхрын ариун цэврийн өрөө, яаралтай тусламжийн өвчтөний хоргүйжүүлэх хэсгийн шүршүүрийн өрөөг засварлан нийт 120 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, орчин үеийн эмнэлгийн шаардлага хангасан тоног төхөөрөмжтэй өвчтөнүүдийн тав тух, эрүүл ахуйн стандартыг хангасан цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлж, хүлээлгэн өглөө

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ НИЙСЛЭЛИЙН ХҮРЭЭ АМАРЖИХ ДЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ



Нийслэлийн Хүрээ амаржих газрын албан хаагчид болон үйлчлүүлэгч эхчүүдийн ариун цэврийн байдал, ая тав тухтай байдлыг хангах үүднээс 160 мкв талбайг угаалгын зориулалттай болгон дотор заслийг стандартыг дагуу засварлан 119 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, цэвэр цэмгэр орчныг бүрдүүлж, хүлээлгэн өглөө.

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ ЧИНГИС ШАР АЙРАГ ХХК



Чингис Шар Айраг хүчин чадлаа нэмэгдүүллээ

Амьд, шинэ айргийг хэрэглэгчдэдээ илүү ойр хүргэх зорилгоор Итали улсын GAI брэндийн 2 литрийн лаазны шинэ савлагааны шугамыг суурилуулж, үйлдвэрийн хүчин чадал болон бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүллээ.

Түүхэн амжилт

Үйлдвэр хүчин чадлаа нэмэгдүүлж, 28 жилийн түүхэндээ анх удаа нэг жилийн дотор 1000 дахь чаналтаа амжилттай хийснээр түүхэн шинэ амжилт тогтоолоо.

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ СЭНТРАЛ КОММЕРС ХХК

Шинэ брэндийг зах зээлд танилцуулав.

Сэнтрал Коммерс ХХК нь дэлхийн анхны пилснер, Чехийн домогт Pilsner Urquell шар айргийг Монголын зах зээлд дахин албан ёсоор танилцуулж, брэндийн дистрибьютерийн эрхийг авлаа. Ингэснээр компанийн брэндийн портфолио өргөжиж, хэрэглэгчдэд илүү олон сонголт санал болгох боломжтой болсон. Мөн энэ алхам нь компанийн борлуулалт, зах зээлийн эзлэх хувийг өсгөх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шинэ боломжийг нээж, Монголын шар айргийн зах зээлд шинэ брэндийг танилцуулж байна.



ЖИНХЭНЭ ПИЛСНЕР ШАР АЙРАГ

21 ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭХ НЬ ТАНЫ ЭРҮҮЛ МЭНДЭД ХОРТОЙ

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ СЭНТРАЛ КОММЕРС ХХК

Asahi Super Dry x Blackpink олон улсын нэгдсэн кампанит ажил:

Asahi Super Dry брэнд дэлхийн алдартай K-POP хамтлаг болох Blackpink хамтлагийг бүрэн бүрэлдэхүүнээр нь брэндийн албан ёсны төлөөлөгчөөр хамтран ажиллах болсон билээ. Энэхүү хамтын ажиллагаа нь Зүүн Азийн зах зээлийг хамарсан анхны нэгдсэн кампанит ажил бөгөөд Япон, Өмнөд Солонгос, Хятад, Хонг Конг, Тайвань, Монгол зэрэг орнуудад нэгэн зэрэг хэрэгжиж байна. Asahi Super Dry болон BLACKPINK-ийн хувьд энэхүү хамтрал нь Зүүн Азийн шар айргийн зах зээлд томоохон нөлөө үзүүлэх түүхэн алхам болох юм. Сэнтрал Коммерс ХХК нь олон улсад хэрэгжиж буй кампанит ажлыг нэгэн хэсэг болж Монголд дахь хэрэглэгч нартаа хүргэж байна

Кампанит ажлын хүрээнд Монгол улсад дараах идэвхжүүлэлтүүд хэрэгжиж байна:

- Asahi Super Dry Limited Edition бүтээгдэхүүнүүд
- Asahi Super Dry x BLACKPINK хамтарсан тусгай мерчүүд
- Сугалаат болон урамшуулалт хөтөлбөрүүд

Asahi Super Dry Ambassador
Asahi Super Dry x Blackpink

PREMIUM NEXUS X

“DRY” BLACKPINK
IN YOUR DRY

3ш = STICKER

6ш = FAN

12ш = TUMBLER

Зөвхөн
БЯМБА БОЛОН НЯМ ГАРАГУУДАД

Asahi Super Dry Ambassador
Asahi Super Dry x Blackpink

1 БҮТЭЭГДЭХҮҮН СУГАЛАА

TUMBLER SILVER & PINK

STICKER SET 5X

FAN

CU App ашиглаад Asahi Super Dry брэндийн бүтээгдэхүүнээс худалдан аваад азтан болоорой.

ХУГАЦАА: 2025.09.15-10.15
ЗӨВХӨН 50 АЗТАНД

ХЭТГҮҮЛЭН ХЭРЭГЛЭХ НЬ ТАНЫ ЗРҮҮЛ НЭМДЭД ХӨРТӨЙ

“DRY” BLACKPINK
IN YOUR DRY

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ СЭНТРАЛ КОММЕРС ХХК

Брэндийн нэр төрлийг нэмэгдүүлэв

Asahi Super Dry брэнд нь хэрэглэгчдийнхээ хэрэгцээ, хэрэглээний нөхцөлд тулгуурлан 2 л болон 135 мл савлагаатай шинэ төрлүүдийг амжилттай нэвтрүүллээ.

Эдгээр шинэ хэмжээ нь хэрэглэгчдэд илүү уян хатан сонголт санал болгож, гэр бүл, найз нөхдийн уулзалт болон хувь хэрэглээнд илүү тохиромжтой болсноор брэндийн хүртээмжийг нэмэгдүүлэх чухал алхам болсон юм.

Шинэ төрлүүдийг 2025 оны 3-р улиралд зах зээлд танилцуулж, Off-trade сувгаар өргөнөөр худалдаалж эхэлсэн нь брэндийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж байна.



2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ СЭНТРАЛ КОФЕ РӨҮСТИНГ ХХК

Олон улсын SCA байгууллагын гишүүнчлэл авч уг байгууллагаар итгэмжлэгдсэн мэргэжилтнүүдтэй боллоо

Сэнтрал Кофе Рөүстинг ХХК нь дэлхийн кофены салбарын тэргүүлэгч байгууллага болох Specialty Coffee Association (SCA)-ийн албан ёсны гишүүнээр элсэж, олон улсын стандарт, аргачлал, сургалт, мэдлэгийн экосистемд нэгдлээ. Энэхүү алхам нь Монголын кофены салбарын чанар, мэргэжлийн түвшнийг дэлхийн жишигт ойртуулах чухал алхам болох юм.

Мөн түүнчлэн манай багийн гишүүд SCA-ийн олон улсын сургалт, шалгалтуудад амжилттай хамрагдаж, амт ба мэдрэхүйн үнэлгээ (Sensory Skills), хууралтын ур чадвар (Roasting Skills), ногоон үрийн чанарын үнэлгээ (Green Coffee) чиглэлүүдээр мэргэшиж, түүнчлэн Q-Grader буюу ногоон үрийн чанар, ангилал, үнэлгээний хамгийн өндөр түвшний мэргэжлийн буюу professional зэрэглэлийн сертификатуудыг амжилттай хүлээн авлаа.



2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ СТОРА ЦЕНТРАЛ ХХК

Технологийн хөгжүүлэлт, АНУ тээврийн хугацааг богиносгох шинэчлэлт болон Байгууллагын худалдан авалтын үйлчилгээ :

Хэрэглэгчийн худалдан авалтын процессын илүү хялбарчлах, ойлгомжтой болгох, цаг хугацааг нь хэмнэх зорилгоор системийн UI-н хэсэгчилсэн шинэчлэлтийг хийсэн. Ингэснээр Стора-н хэрэглэгчид барааг сагслалгүй шууд худалдан авах, өөрийн тогтмол ашигладаг төлбөрийн хэрэгсэл, Сторабокс-оо хадгалан нэг товчоор дээрх бүх үйлдлийг хийх, захиалсан барааны тээвэрлэлтийн төлөвийг илүү нарийн ойлгомжтойгоор харах шинэчлэлтүүдийг хийв.

АНУ-с Стора-н хэрэглэгчид дунджаар 14-17 хоногт бараа бүтээгдэхүүнээ гар дээрээ авдаг байсан хугацааг 8-10 хоног болгон бууруулав. Ингэснээр хэрэглэгчид өмнөхтэй ижил тээврийн үнээр илүү богино хугацаанд захиалсан бараагаа авах боломж бүрдсэн. Стора Централ ХХК нь ложистикийн үйл ажиллагаагаа сайжруулан, хамтын ажиллагааг тэлж, дотооддоо тээврийн чиглэлээ удирдах боломжийг бий болгосноор энэхүү үнэ цэнийг хэрэглэгчдэдээ авчирч чадлаа.

Байгууллагын харилцагчдад зориулсан худалдан авалт болон хангамжийн материал захиалгын шийдэл Стора платформ дээр нээгдэв. Ингэснээр албан байгууллагууд Хятад болон АНУ-с илүү хямд үнэ, төлбөрийн уян хатан нөхцөл, тээврийн үйлчилгээ, гаалийн бүрдүүлэлт, хүргэлтийн үйлчилгээг цогцоор нь Стора-с авах боломжтой болсон бөгөөд худалдан авалтын үнийн дүнг бууруулах хэлэлцээрийг Стора харилцагчийн өмнөөс хийж өгөх үйлчилгээг мөн нэвтрүүлсэн нь компаниудын хангамжийн албаны ажлыг хөнгөвчлөх шийдэл болж чадлаа



Байгууллагын үйлчилгээ

Тав тух бүтээх дижитал шийдлийг бий болгогч

Хүсэлт илгээх →

Оффис тавилга

Бүхий л төрлийн оффисын тавилгын өргөн сонголтыг хэмнэлтэй зардлаар нийлүүлэх боломж

Оффис хэрэглээний электрон бараа

Суурин болон зөөврийн компьютер, тэдгээрийн дагалдах хэрэгсэл, камер, дэлгэц гэх мэт бүх төрлийн электрон...

Компанийн хангамжийн материалууд

Оффисын бүхий л төрлийн хангамжийн материалыг энд борлуулдаг үнээс илүү хямд нөхцлөөр ханган нийлүүлнэ

Үйл ажиллагааны онцлог бүрт тохирсон тоног төхөөрөмж, бараанууд

Таны бизнесийн онцлог, үйл ажиллагааны салбарт шаардлагатай тоног төхөөрөмж болон барааг бүх...

Хүсэлт илгээх →

2025 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд

■ СТОРА ЦЕНТРАЛ ХХК

Apple-н цоо шинэ загваруудыг хуваан төлөлт болон зээлээр урьдчилан захиалах боломж


iPhone 17-н бүх загварууд болон шинэ үеийн iWatch, Earpods-г нээлтийн өдөртэй давхцуулан урьдчилан захиалах боломжийг бий болгож татан авалт болон тээврийн хугацааг илүү сайжруулснаар Стора-н хэрэглэгчид бусдаас түрүүлж шинэ загваруудыг өөрийн гар дээр авах боломжийг бүрдүүлэв.

Нэмээд хуваан төлөлт болон зээлийн үйлчилгээг Apple-н урьдчилсан захиалга дээр бий болгосон нь хэрэглэгчдэд илүү үнэ цэнийг үүсгэж чадав.

Amazon Prime Day

Амазоны жилийн хамгийн том хямдрал болох Prime Day-р Стора-н хэрэглэгчид бүх бүтээгдэхүүнийг 90% хүртэл хямдралтайгаар худалдан авах боломжтой байдаг бөгөөд тус хямдралыг Стора-р дамжуулан шууд эдлэхээс гадна зээлийн болон хуваан төлөх үйлчилгээг давхар ашиглах боломжтойгоороо онцлог байдаг. Энэ удаагийн хямдралаар Стора-н АНУ дахь тээврийн хугацаа богиноссон нь хэрэглэгчид давхар сэтгэл ханамжийг бий болгов.





НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтүүдийн товч танилцуулга

■ НЭГТГЭСЭН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТОВЧ ТАЙЛАН

/MNT million/	2023 Q3	2024 Q3	2025 Q3
Net Sales Revenue	278,855.4	433,958.0	587,084.3
COGS	264,200.4	353,033.7	474,149.1
Gross profit	14,655.0	80,924.3	112,935.2
Gross margin	5.3%	18.6%	19.2%
Operating Expenses	9,558.0	17,303.7	36,550.4
EBITDA	5,097.0	63,620.6	76,384.8
EBITDA margin	1.8%	14.7%	13.0%
Depreciation & Amortization	20,020.4	24,429.3	33,487.2
Non-cash items	1,827.1	2,159.0	2,679.0
EBIT	(13,096.3)	41,350.3	45,576.6
Financing cost	12,766.7	14,417.8	16,417.5
EBT	(25,863.0)	26,932.5	29,159.1
Income tax	(14.4)	582.2	2,766.9
Net Profit/(loss)	(25,848.6)	26,350.3	26,392.2
Net profit margin	-9.3%	6.1%	4.5%

Тайлбар: Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтүүдийн товч танилцуулга

■ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/MNT million/	12/31/2023	12/31/2024	9/30/2025
Total current assets	40,170.3	78,428.9	116,783.4
Cash and cash equivalents	2,980.6	10,431.5	10,258.6
Accounts receivables	641.3	6,042.3	7,613.8
Inventory	28,250.0	47,194.5	70,768.7
Other current assets	8,298.4	14,760.6	28,142.4
Total non-current assets	153,324.6	235,502.5	291,746.0
Tangible and Intangible assets	90,193.8	157,907.5	200,825.5
ROU assets	50,534.8	60,568.6	73,826.6
Other non-current assets	12,595.9	17,026.4	17,093.9
TOTAL ASSETS	193,494.9	313,931.5	408,529.5
Total current liabilities	116,172.9	116,242.6	125,901.8
Accounts payables	42,916.4	56,829.4	72,394.3
Current loans and borrowings	19,969.9	25,360.3	19,435.0
Other current liabilities	53,286.5	34,052.9	34,072.6
Total non-current liabilities	91,590.7	94,900.0	151,505.3
Non-current loans and borrowings	33,882.0	23,888.1	54,204.8
Other non-current liabilities	57,708.6	71,011.9	97,300.5
Total equity	(14,268.7)	102,788.8	131,122.3
Common shares	81,776.9	111,425.2	111,425.2
Share premium	13,820.5	45,757.9	45,757.9
Other parts of equity	318.7	318.7	318.7
Non-controlling interests	-	8,873.4	15,870.3
Retained earnings	(110,184.8)	(63,586.4)	(42,249.8)
TOTAL EQUITY AND LIABILITIES	193,494.9	313,931.5	408,529.5

Тайлбар: Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтүүдийн товч танилцуулга

■ НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/MNT million/	2023 Q3	2024 Q3	2025 Q3
Cash flows from operating activities			
Cash inflow (+)	323,325.1	503,436.3	672,962.0
Cash outflow (-)	(307,177.8)	(455,919.3)	(609,059.1)
Net cash flows from operating activities	16,147.3	47,517.0	63,902.9
Cash flows from investing activities			
Cash inflow (+)	444.6	894.2	1,195.8
Cash outflow (-)	(20,794.0)	(23,676.9)	(69,946.2)
Net cash flows used in investing activities	(20,349.4)	(22,782.7)	(68,750.3)
Cash flows from financing activities			
Cash inflow (+)	26,800.0	46,481.1	417,972.8
Cash outflow (-)	(23,878.8)	(64,877.1)	(413,166.5)
Intercompany transactions (+/-)	-	-	-
Net cash flows from/used in financing activities	2,921.2	(18,396.0)	4,806.3
Cash and cash equivalents foreign exchange difference	(67.4)	(91.5)	(131.8)
Net cash flows	(1,348.2)	6,246.9	(172.9)
Cash and cash equivalents beginning balance	4,280.7	2,980.6	10,431.5
Cash and cash equivalents ending balance	2,932.5	9,227.5	10,258.6

Тайлбар: Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт



Анхаарал хандуулсанд

БАЯРЛАЛАА

Холбоо барих:
И-мэйл: investor@cumongol.mn